

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2022 оны 01 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан

2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Нэгдүгээр сард 18 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 5 ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна. Ирсэн захирамж, тогтоол-8, удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 6 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Нийт ирүүлсэн өргөдөл 4 (ажлын байр хүссэн-4) байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2022 оны 01 дүгээр сарын байдлаар төрсний бүртгэл -2 / эм -2/, гэрлэсний бүртгэл -1, Иргэний үнэмлэх шинээр /16 нас/ - 3 / эр -1, эм-2/, шилжин ирсэн -1, лавлагаа -3 иргэн тус тус бүртгэгдсэн.

Төсөв санхүүгийн талаар

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн сарын хуваарийг хийж ЗГУМС-д татуулж шивүүлсэн. Жилийн эцсийн төсөвт байгууллагуудын эд хөрөнгийн тооллогыг нэг бүрчлэн хийж хөрөнгийг акталж устгах, данс бүртгэлд тусгах, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай 2022 оны гэрээ хийх, 2021 оны тооцоо нийлж акт үйлдэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ. Төсөвт байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж Сүхбаатар аймгийн төрийн аудитын байгууллагад шалгуулахаар хүргүүллээ.

Худалдан авах ажиллагааны 2021 оны тайланг илгээж, 2022 оны төлөвлөгөөг цахимд нийтэлсэн. ОНХС-аар хийгдсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг ОНХС-ийн вэб сайтад нийтэллээ. Төсөвт байгууллагуудын данс өөрчлөгдөж гарын үсгийн баталгааг эрхийн бүртгэлийн санд байршууллаа.

Төрийн сангийн 1-12 сарын баримтыг үдэж архивлан архивийн нэгж үүсгэлээ. Мөн орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн баримт материалыг үдэж цэгцлэн төрийн аудитын байгууллагад шалгуулахаар бэлдлээ.

Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайланд аудит хийж шалгуулахаар шаардлагатай баримтыг гаргаж өгөх, дотоод хяналтын судалгааг гаргаж хүргүүллээ.

Статистикийн 4-р улирлын мэдээг хугацаанд хүргүүлж ААНБ-ын татварын тайлан, санхүүгийн тайланг цахимд хийж илгээлээ.

Татварын чиглэлээр:

Хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх хуулийн хүрээнд хийгдэж байгаа тайлант ажил 4 хүний материал ирсэн. Үүнийг Етах-д бүрдүүлэх материалын дагуу материалаа хүлээн авч байна. Хүүхдийн мөнгөний шинэчлэсэн журмаар ебаримт-д холбогдож баталгаажуулах, иргэдийн утсанд ебаримт татаж өгөх үйлчилгээг нийт 10 иргэнд үзүүллээ.

Авто тээврийн газраас тээврийн хэрэгслийн татварын өртэй хүмүүсийн нэгтгэл ирж 500 гаруй иргэнтэй утсаар ярьж мэдээлэл өгсөн. Үүнээс өөрийн нэр дээр байдаг боловч зарсан, хамаатан садандаа шилжүүлсэн, эвдэрсэн машин техникээ өөрийн нэрээс хасалт хийлгээгүй иргэдэд зөвөлгөө өгч ажиллаа.

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

2021 газар өмчлөх хүсэлт гаргасан 48 иргэний нэгж талбарын хувийн хэргийг шинэ хавтас үүсгэн холбогдох материалуудыг хуулбарлан цахим хувийн хэрэг үүсгэн ажилласан байна.

Дуудлага худалдааны ялагчаар тодорж гэрээ байгуулан газрын үнээ төлсөн иргэний өргөдлийг бүртгэн ажилласан

Мөнххаан сумтай хиллэдэг “Залаагийн булаг” гэх газар айлын өвөлжөө хаваржааны газрыг мөнххаан сумын малчин манай газар нутагт ордог хэмээн олон мал авчран талхлаад байна гэсэн өргөдөл ирсэн. Уг өргөдлийн дагуу Засаг даргын орлогч Х.Баттөртэй хамтран газар дээр нь ажиллаж, хилийн цэсийн дотор орж буй эсэхийг тогтоож иргэний гомдлын хариуг өгсөн.

Байгаль орчны чиглэлээр:

Усны чиглэлээр:

Цөлжилт газрын доройтлыг бууруулах зорилшоор 2020 онд Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Зүүнбулгийн эхийг хашиж хамгаалж нөхөн сэргээх ажлыг Хөдөө аж ахуйн их сургуулийн Аргозкологийн баг бүрэлдэхүүн гүйцэтгэж үр дүнг орон нутаг хүлээн авсан. Иймд цаашид эд хөрөнгө бүрэн бүтэн байдлыг хариуцах байгууллагыг тодорхойлох зорилгоор Иргэдийн тэргүүлэгчдийн ээлжит 6 дугаар хуралдаанаар оруулан батлуулж хариуцах байгууллагыг Засаг даргын Тамгийн газарт харицуулахаар баталсан.

Уул уурхайн чиглэлээр:

Сумын нутаг дэвсгэрийг хамгаалах, сөрөг үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Зарим газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай” саналыг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулан батлуулж Ашигт малтмал газрын тосны газарт хүргүүлсэн. Тус тогтоолын хариу Ашигт малтмалын тухай хуулийн 14.2 дох заалтыг хангахгүй байна гэсэн хариу ирүүлсэн. Үүний дагуу нягтлан үзэж тус тогтоолыг Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит 6 дугаар хуралдаанаар оруулан батлуулж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

“Аймгийн аварга малчин”-д Уулбаян сумын хэмжээнд 3 малчны материалыг 3 багийн засаг дарга, мал эмнэлэгийн тасгийн дарга Ж.Соёлсүх нартай хамтран бүрдүүлж холбогдох журмын дагуу 2022 оны 01 дүгээр сарын 05-нд Сүхбаатар аймгийн ХХААГазарт хүргүүлсэн. Баян багийн малчин Б.Батхуяг, Жавхлант багийн малчин С.Энх-Оргил, Дэлгэр багийн малчин Л.Юмсүрэн нар “Аймгийн аварга малчин”-аар шалгарсан.


Сумын аварга малчны материалыг 5 багийн засаг дарга, Мал эмнэлэгийн тасгийн дарга Ж.Соёлсүхтэй хамтран 10 малчин өрхийн материалыг Сумын засаг даргын зөвлөлөөр оруулж 10 малчин дэмжигдсэн.

МҮОНТ-ээс зохион байгуулдаг “Алтан төлийн эзэн”-ийн шагналд 3 малчин өрхийн материалыг холбогдох журмын дагуу бэлтгэн 2022 оны 01 сарын 08-нд Сүхбаатар аймгийн ХХААГазарт хүргүүлсэн. Баян багийн малчин У.Бадрах, Цогтсайхан нар “Алтан тугалын эзэн”-ээр, Дэлгэр багийн малчин М.Алтансүлд “Алтан хурганы эзэн”-д тодорхойлсон. Сүхбаатар аймгийн ХХААГазраас С.Цогтсайхан, М.Алтансүлд нарын материал дэмжигдэн МҮОНТелевиз рүү хүргүүлсэн.

Аймгийн аварга малчны шагналыг 2022 оны 01 сарын 22-нд Сүхбаатар аймгийн орлогч дарга Д.Шижирбаатар болон Уулбаян сумын удирдлагууд малчны хотонд гардуулсан. Мөн Сумын аварга малчин 10, Мянгат малчин 8, Сумын алдарт уяач 2 тодорсон бөгөөд 2022 оны 01 сарын 20-нд шагналыг гардуулан хүдэтгэл үзүүлсэн.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр:

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа 2022 оны 01 сарын 17-ны байдлаар.



Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц болон татан авалтын хомсдол үүсээгүй, тээвэрлэлт хэвийн явагдаж байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим, түргэн гэмтэж чанар байдлаа алдах, хүнсний бүтээгдэхүүнийг техникийн зохицуулалтад заагдсан горимд хадгалж байгаад хяналт тавин хоол хүнсээр, дамжих өвчин, хордлого, халдвараас урьдчилан сэргийлэх, зорилгоор мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, зөвлөгөөг тогтмол хүргэн ажиллаж байна.

Шатахуун түлшний үнэ нөөц 2022 оны 1 сарын 18-ны байдлаар

№	Байгууллагын нэр	A-80	A-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	6.8тн	17тн	6тн
2	Үнэ	2450төг	2500төг	3030 төг

№	Байгууллагын нэр	A-80	A-92	ДЗ
1	“Арвижих Дарь” ХХК	4тн	5.1тн	5.3 тн
2	Үнэ	2470 төг	2480 төг	3030 төг

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгааг 12-01 сартай харьцуулан харуулав.

№	Бүтээгдэхүүний нэр		2021 оны 12 сарын 20 байдлаар	2022 оны 1 сарын 21 ны байдлаар
1	гурил	Дорнод дээд	36000	36000
		УБ 1-р зэрэг	37000	38500
		Дорнод 2-р зэрэг	29500	29500
2	Цагаан будаа		3000-3500	3000-3500
3	Шингэн сүү		3700	3800-3900
4	Хуурай сүү		6500-12500	6500-12500
5	Элсэн чихэр		3000-3500	3000-3500
6	Ургамлын тос		5800-6500	6200-7500
7	Өндөг		650-700	650-700
8	Төмс		1300-1500	1300-1500
9	Хүнсний ногоо	Сонгино	3000	3000-3500

		Байцаа	2500-3000	2500
		Лууван	2200	3500
		Сармис	2500	3000
10	Давс		1000-1500	1000-2800
11	Савласан ус		800-3500	900-4000

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний зохиомол үнийн хомсдол үүсээгүй байна

Худалдааны чиглэлээр “Монгол хүнс- Монгол бараа 2022” арга хэмжээ хүнс өргөн хэрэглээний борлуулалтыг дэмжих, иргэдийн хэрэгцээнд нийлүүлэх зорилгоор 2022 оны 01 сарын 20-30ны өдрүүдэд төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн худалдаанд сумаас 2 иргэн цагаан сард хэрэглэгдэх ууцаар оролцож байна.

Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газраас Иргэд аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний каталог хийгдэж байгаатай холбогдуулан сумандаа жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг “Эрчтэй дээс монгол гэрийн өрх, Эсгийгээр урласан буйдангийн ширмэл, Нутгийнхаа хөрсөнд тарьж ургуулсан Даршилсан ногоо” гэсэн 3 бүтээгдэхүүний танилцуулга, бусад мэдээллийг явуулсан.

Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр:

2021 оны 12 дүгээр сарын 29-ны байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 5,509,777 төгрөг сум хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлөгдсөн байна.

Эргэн төлөлт тогтмол хийж буй 9 зээлдэгчид:

- 2013 онд зээл авсан – Г.Зоригт
- 2019 онд зээл авсан - С.Эрдэнэбат, Ц.Мөнхцогт, Ю.Сэсээрдорж
- 2020 онд зээл авсан - Б.Цэрэнхүү, Ч.Цогзолмаа, А.Отгонхүү, Ч.Цогзолмаа

Сум хөгжүүлэх сан нь “Хоршоо хөгжүүлэх сан” болж өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор 2022 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэх журмыг талаарх мэдээллийг иргэдэд Хөдөө аж ахуйн тасгийн хуудсаараа дамжуулан

2021 онд Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдэд зээлийн хүү, эргэн төлөлтөө хувиарын дагуу хугацаанд нь төлж байх мөн сум хөгжүүлэх сангийн зээлдэгчийн мэдээлэл Монгол банкинд шилжиж зээлээ хугацаандаа төлөхгүй удаашралтай бол муу зээлдэгчийн ангилалд орж дахин зээл авах боломжгүй болсон зөвлөгөөг тогтмол хүргэн ажиллаж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн бодлогын чиглэлээр:

Хүүхдийн статистик тоон мэдээллийн судалгааг боловсруулж, аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн. Мөн хүүхэд залуучуудын хөгжил хамгааллын асуудлаар энэ онд хийгдэх ажлын саналыг аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн.

Мөн эрүүл мэндийн төвд 30-60 насны эмэгтэйчүүдийн судалгаа, суурин хүн ам хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа зэргийг гаргаж өгч хүргүүлсэн. Мөн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргасан

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

1.Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдсан 12 иргэдийн үлдэгдлийг утсаар баталгаажуулж ажилласан.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

1. Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж, асаргаа сунгуулах 10 иргэний материалыг, Тэжээн тэтгэх үр хүүхэдгүй 1 ахмадыг түлээ нүүрсний хөнгөлөлтөнд хамруулсан.

2. 1 сарын хүнсний эрхийн бичгийг үйлчилгээнд 13 өрх хамрагдаж байгаа. 4. Шинээр төрсөн 1 хүүхдийн өргөдлийг хүлээн авч программд бүртгүүлсэн.

3.Цалинтай аав хөтөлбөрт 1 иргэн хамрагдсан.

4. Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 752хүүхдийн хүсэлтийг илгээсэн. Мөн шинээр төрсөн 2 ихэр хүүхдийг 2,000,000 төгрөгний бүртгэлд хамруулсан. Мөн Цагаан сарын баярыг тохиолдуулан Төрийн харъяалалгүй 244 ахмадад хүндэтгэл үзүүлсэн.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 45761.0 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -40100.8 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 3492.9 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 2167.3 мян төг орлоо.

Хэлтсээс 0 мян төгрөгийн санхүүжилт авч 461 тэтгэвэр авагчдад 167106.5 мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДДаатгалд 41 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулсан 3492.90 мян төгрөгийн шимтгэл, Эрүүл мэндийн даатгалд 46 даатгуулагчийг даатгаж 2167.3 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -2, тахир дутуугийн тэтгэвэр-0, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -0 нийт 0 тэтгэврийг тогтоож, 4 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоон олгоод байна.

Улсын төсвөөс 0 сая төгрөгийг тэтгэмжийн санхүүжилт оршуулгын тэтгэмж 1 тэтгэвэр авагчдад 1000.0 мян төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 1 даатгуулагчдад 2484,3 мян, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 2 даатгуулагчдад 147,0 мян төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

2021 оны харилцахын-4, тооцооны хуудас тайлан-2, хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан-1, малчны зөвлөлийн тогтоол баримтууд -1 зогсоогдсон 27 тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-2, т Банк солих-1, тэтгэмж-3, ажилгүйдлын тэтгэмж-0, малчин малчнаар ажилласан жил тогтоолгох- 0 нийт 5 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж, 34 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Нийгмийн даатгалын хэлтсээс 1 сарын 9-12 өдрүүдэд зохион байгуулсан сургалтанд амжилттай оролцож, 2021 оны тайланг нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өглөө.

Ерөнхий боловсролын сургууль :

- Нийгмийн ажилтан Т.Вера 2021 онд Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, хамтарсан багийн үйлчилгээг холбогдох журмын дагуу шуурхай үзүүлж, хуулиар хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж “Шилдэг нийгмийн ажилтан” боллоо
- Ангий удирдсан болон мэргэжлийн багш нар “Хүүхдийг болзшгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх”, “Цахим орчинд эрсдлээс өөрийгөө хамгаалаарай хүүхдүүд ээ”, “Халдвар хамгааллын дэглэмээ баримталцгаая”, “Хүүхэд бидний ирээдүй”, “Зөвлөмжийг дагаж мөрдөөрэй”, “Хүүхдийг ахуйн ослоос урьдчилан сэргийлье”, “Хүүхдийн аюулгүй байдал”, “Ковид 19 цар тахлын омикрон хувилбараас сэргийлье”, “Амны хаалтаа зөв зүүгээрэй”, “Гараа тогтмол угаагаарай”, “Дархлаагаа дэмжицгээе”, “Бяцхан үрсээ эерэг аргаар хүмүүжүүлцгээе”, зэрэг сэдвээр нийт 25 шторк бэлтгэн сургуулийн нээлттэй группэд байршуулав.
- Байгаль орчин аялал жуулчлалын яам, Дэлхийн байгаль хамгаалах сангаас зохион байгуулсан " Хээр, зээр, бид 3" бүтээлийн уралдаанд 9а ангийн сурагч О.Болор-Эрдэнэ амжилттай оролцож Дэд байр эзлэв.
- Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулж буй “ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛЫГ ТАНИУЛАХ” 2 өдрийн цахим сургалтад Бага ангийн багш, Химийн багш, Дүрслэх, дизайн технологийн багш нар хамрагдлаа.

- Сурагчдын амралтын хугацаанд Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтээс 1-р сарын 24-нөөс 2-р сарын 07-нд цахимаар зохион байгуулж буй “СӨБ, ЕБС-ийн багш, ажилтны сонголтот сургалт”-д 29 багш, удирдах ажилтан хамрагдлаа.
- Хууль эрх зүйн мэдлэгийг дэшлүүлэх зорилгоор багш, удирдах ажилтныг 7 багт хуваан “МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ, “ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ”, “МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ”, “СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬ”-ийг уншиж судалж байна.

Хүүхдийн цэцэрлэг:

- Цэцэрлэгийн амралт эхэлсэн хэдий ч 4-5 насны 41 хүүхдийг 2 бүлэгт хүлээн авч үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.
- Монгол Улсын Үндсэн хуулийн АХА тэмцээн манай байгууллагаас 3 хүн оролцож туслах багш Л.Сарангоо 2-р байр эзэллээ.
- Аймгийн аудитын газраас авдаг санхүүгийн бичиг баримтыг файл болон цаасаар бэлтгэн хүргүүллээ.
- Халдвар хамгааллын дэглэмээ нарийн баримтлан цэвэрлэгээ үйлчилгээгээ тогтмолжуулан ажиллаж байна.
- Аймагт зохион байгуулагдсан “Би-Залуу багш” хөтөлбөрийн сургалтыг ажлын байран дээр зохион байгуулж 13 хүнийг хамрууллаа.
- Ковид-19 өвчний халдварлалт ихсэж байгаатай холбогдуулан байгууллагын “Тандалтын баг” өдөр бүрийн хүүхдийн ирцэнд тандалт судалгаа хийн ажиллаж байна.
- “Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт илтгэлийг сайжруулан засаж боловсролын газарт илгээлээ.
- Долоо хоног бүрийн баасан гаригт бүх анги бүлгүүдэд их цэвэрлэгээ, болон автомаксаар халдваргүйжүүлэлтийг хийж байна.

Соёлын төв:

Манай байгууллага нь мэргэжлийн 6 гэрээт 2 гэсэн нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 оны 1 сарын 9-нд Дуучин Ц.Түмэн-өлзий,МУСТА Т.Даваасүрэн нарын хийморьлог аялгуу тоглолтыг хүлээн авч, техник хэрэгслээр туслан халдвар хамгааллын дэглэмийг чандлан баримталж 50%-ийн дүүргэлттэй ажиллалаа. 2022 оны 1 сарын 15 нд Баялаг бүтээгчдын үзэсгэлэн худалдааг халдвар хамгааллын дэглэмийг чандлан баримталж АОК-ийн шийдвэрийн дагуу 50%-ийн дүүргэлттэй үйл ажиллагаагаа явуулсан.амжилттай зохион байгуулж ажиллалаа.

Эрүүл мэндийн төв:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэл:

Уулбаян эрүүл мэндийн төв нь 5-н багийн 2908 хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай жигд хүртээмжтэй үзүүлэн ажиллаж байна.

- Хүний нөөц: Их эмч 2, бага эмч 4, сувилагч 6, туслах сувилагч 3, лаборант 1, нягтлан 1, нярав 1, тогооч 1, жолооч 1, галч 3 нийт 23 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.
- Хүлээн авахын угтах лавлах үйлчилгээр 162 хүн үйлчлүүлээд байна.
- Тусламж үйлчилгээ
 1. Бүгд үзлэг 240
 2. Амбулаторын үзлэг 165
 3. Урьдчилан саэргийлэх үзлэг 126
 4. Идэвхитэй хяналт 19
 5. Хэвтэн эмчлүүлсэн 31 үүнээс ковидоор хэвтэн эмчлүүлсэн 11 үүнээс
 6. Өдрийн эмчилгээ 16
 7. Алсын дуудлага-17
 8. Гэрийн дуудлага 20

Товлолт дархлаажуулалтын чиглэлээр:

Товлолт дархлаажуулалтанд 0-2 насны 25 хүүхдийг хамруулсан.

Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний чиглэл:

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4-н төрлийн тусламж үйлчилгээ авдаг Үүнээс 1 дүгээр сарын байдлаар:

- Өдрийн эмчилгээ 14 үйлчлүүлэгчид 1.083.460
- Гэрийн эмчилгээ- 0
- Сэргээн засах -0
- Оношилгоо , шинжилгээ 45 үйлчлүүлэгч 474,500 санхүүжилтийг одоогоор хийн ажиллаж байна.

Тушаал шийдвэрийн талаар:

Аймгийн засаг даргын А/35 тоот захирамжийн дагуу Тандалтын 1 баг нь 3-н хүний бүрэлдэхүүнтэй , хариу арга хэмжээний 2 багийг 4 хүний бүрэлдэхүүнтэй томилсон.

Халдвартын тасагт нэмэлтээр ковидын 7 ор, хэвтэн эмчлүүлэх тасагт ТТӨ ихэссэнтэй холбоотой нэмэлтээр хүүхдийн 4 ор, насанд хүргэгчдийн 4 орыг дэлгэн ажиллаж байна Эм эмнэлгийн хэрэгсэл, ковидын түргэвчилсэн оношлуур, хамгаалах хувцас, ариутгалын бодис 3-7 хоногийн нөөцтэй ажиллаж байна. Хамгаалах хувцас хэрэглэлд 2,5 сая, түргэвчилсэн оношлуурт 3,0 сая төгрөг зарцуулсан

Коронавируст халдварын тандалт эмчилгээний талаар

Тандалтын 1 баг нь 3-н хүний бүрэлдэхүүнтэй, хариу арга хэмжээний 2 багийг 4 хүний бүрэлдэхүүнтэй томилсон. Коронавируст халдвар ковид -19 нийт тохиолдол 410 үүнээс 2022 оны 01 дүгээр сарын 10 нд бүртгэгдэж одоогоор 42 тохиолдол бүртгэгдээд байна. Коронавируст халдвараар сумын тусгаарлан эмчлэх тасагт 12 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн. Үүнээс хүүхэд 4, насанд хүрэгчид 8 байна. Эдгэрч гарсан 9 үүнээс насанд хүрэгчид 8, хүүхэд 1, хэвтэн эмчлүүлж байгаа хүүхэд 3 байна. Гэрийн багц эмчилгээнд 30 үүнээс, хүүхэд 12, насанд хүрэгчид 18 байна. Эдгэрсэн гэрийн ажиглалтанд шилжсэн хүүхэд 2 нийт эдгэрсэн 11. Гэрийн эмчилгээнд байгаа үйлчлүүлэгчийн биеийн байдлыг өдөр бүр утсаар тандаж ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн 1 сувилагч халдвараар өвдөөд эдгэрсэн.

Ковидын вакцинжуулалтын талаар:

Ковид -19 халдварын нэмэлт тунгийн дархлаажуулалтанд 2022 оны 1 дүгээр сарын байдлаар 126 иргэн хамруулсан.

- 1-р тун 2220/1992 буюу 89,7%
- 2-р тун 2220/ 1874 буюу 84,4%
- 3-р тун 2220/ 939 буюу 56,9 %
- 4-р тун 2220/ 60 буюу 2,7хүн хамрагдсан байна.

Сургалт сурталчилгааны чиглэлээр:

Уулбаян эрүүл мэндийн төв цахим хуудсаар коронавируст халдвар ковид-19 халдвараас сэргийлэх зөвлөмж зөвлөгөө мэдээллийг өдөр бүр байршуулж ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож байна. Цахимаар 24 төрлийн зөвлөгөө зөвлөмжийг байршуулж цахим хандалт 138, дотоодын сургалтыг 1 удаа 18 эмч мэргэжилтэнд, эрүүл мэндийн газар болон эрүүл мэндийн яам, нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс 8-н удаагийн цахим хурал, сургалтанд давхардсан тоогоор 35 эмч мэргэжилтэн хамрагдсан.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны Эрх зүйн төлөвлөгөөний төсөл боловсруулсан.

ЗДТГ-ын Дотоод хяналт шалгалтын багаас 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын удирдлагаар батлуулсан.

Сумын Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Сумын Засаг даргаас багийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээ, Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн жинхэнэ албан

хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны хөтөлбөр, Төрийн албан хаагчийн сургалтын 2022 оны төлөвлөгөө зэргийг боловсруулж, төсөл хэлбэрээр бэлтгэсэн.

2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Соёлын тухай хуулиудыг хэн сайн мэдэх вэ тэмцээнийг 2022.01.24-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөсөн боловч аймгийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамжаар түр хойшлогдсон.

Хүчингүй болсон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон шинэчилсэн найруулга хуулиудын хоорондын ялгаа, өөрчлөлтийг жишин харьцуулж, пүрэв гарагийн мэдээллийн цагт байгууллагын нийт албан хаагчдад танилцуулсан.

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаас 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн хуулиудын талаар иргэд олон нийтэд эрх зүйн мэдлэг, мэдээллийг тогтмол хүргэж байна.

Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн сул орон тооны зарлалыг нийтэд танилцуулж, 1 иргэн өргөдөл ирүүлсэн.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 2 албан тушаалтнаар гаргуулж, үлдсэн албан тушаалтнуудыг хуулийн хугацаанд гаргах үүрэгтэй талаар зөвлөгөө, арга зүйн зөвлөмжийг тогтмол өгч ажиллаж байна.

Сумын Шуурхай штабаас аймгийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамжийн биелэлт, Улсын Онцгой Комиссын 2022 оны 121 дүгээр албан тоотоор өгөгдсөн үүргийн биелэлтийг тус тус хугацаанд нь хүргүүлсэн. Энэ сард гэмт хэрэг-3, зөрчил-1 тус тус бүртгэгдсэн байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ